



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар A/74

Улаанбаатар хот

Хяналтын хуудас шинэчлэн батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 479 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмын 16.1, 16.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зам, тээврийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх Авто тээвэр, Авто зам, Усан замын тээврийн чиглэлээр шалгах хяналтын хуудсыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Хавсралтаар баталсан хяналтын хуудсыг цахим хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлэн үйл ажиллагаанд ашиглахад улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Салбарын хяналтын газрын дарга, Салбарын улсын ерөнхий байцаагч /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар (Х.Оюунтуяа)-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Хяналтын хуудас батлах тухай" А/19 дүгээр тушаалын 1, 6, 7, 8, 9, 10, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 35 дугаар хавсралтуудыг хүчингүй болсонд тооцсугай.



6500000000

Зам, тээврийн яамны Төрийн нарийн  
бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын  
28.-ний өдрийн 11:11 дугаар  
тушаалын хавсрал

ШИНЭЧЛЭГДСЭН ХЯНАЛТЫН ХУУДАС

8024070012 501437 00000257000

№	Хяналтын чиглэл	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр
1	Авто тээврийн хяналтын чиглэл	04.1.1	Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг эрхлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
2		04.1.6	Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
3		04.1.7	Аюултай ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах хяналтын хуудас
4		04.1.8	Ачаа тээврийн автомашин /чиргүүл/-ыг шалгах хяналтын хуудас
5		04.1.9	Ачаа тээвэрлэлтийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас
6		04.1.10	Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагыг шалгах хяналтын хуудас
7		04.1.17	Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
8	Авто замын чиглэлийн хяналтын хуудас	04.2.1	Гүүрийн угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудас
9		04.2.2	Гүүрийн арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудас
10		04.2.3	Авто замын угсралт, шинэчлэлт, их болон ээлжит засварын ажлыг шалгах хяналтын хуудас
11		04.2.4	Авто замын арчлалт хамгаалалт, урсгал засварын ажлыг шалгах хяналтын хуудас
12		04.2.5	Агаарын хөлгийн хөөрч буух зурvas, явгалах зам, перрон, зогсоол болон бусад зам талбайн угсралт, шинэчлэлт, засварын ажлыг шалгах хяналтын хуудас
13		04.2.6	Авто зам, замын байгууламжийн техник, технологийн хяналт гүйцэтгэх ажлыг шалгах хяналтын хуудас

14		04.2.7	Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах хяналтын хуудас
15		04.2.8	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд ашиглах материал, бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, заводын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
16		04.2.9	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
17	Усан замын хяналтын чиглэл	04.4.1	Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас

-- оОо --